



**“ДА ХҮРЭЭ ТРЕЙД” ХХК-ИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

РД: 2063115

Улаанбаатар хот

2024 он

АГУУЛГА

ОРШИЛ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
 - 2.1 Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээ;
 - 2.2 Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн талаар;
 - 2.3 Осол, эрсдлийн менежментийн талаар;
 - 2.4 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт;
 - 2.5 Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт;
 - 2.6 ДҮГНЭЛТ

3. ХАВСРАЛТ

ОРШИЛ

“Да хүрээ” авто худалдааны төв нь Баянзүрх дүүргийн 9-р хорооны нутаг дэвсгэрт 6,5 га талбайд худалдаа үйлчилгээний 5 байр, битүү болон задгай автосалон, сэлбэгийн дэлгүүр, зоогийн газар зэрэг 200-аад барилга байгууламж, стандартын дагуу засаж тохижуулан, худалдах авто машины 1500, үйлчлүүлэгчдийн 300 гаруй зогсоолтой бөгөөд байгаль орчинд ээлтэй “Эко” орчин бүрдүүлэх зорилтыг удирдлага болгон ажиллаж байна.

Дэд бүтцээс алслагдсан байдал, газар ашиглалт, гудамж замын сүлжээ, үйлчилгээний таатай орчин бүрдээгүй, хөрс агаарын бохирдлыг бууруулах зэрэг тулгамдсан олон асуудлыг шийдвэрлэх зорилгоор Улаанбаатар хотын 2020-2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, “Шархад дэд төв”-ийн төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан “Да хүрээ” авто худалдааны төв байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулсан.

Энэ төлөвлөгөөний дагуу “Үйлчилгээ, дулаан зогсоол”-ын зориулалттай 2 давхар барилга угсралтын ажлыг 2019 онд эхлүүлж, 3 тэрбум гаруй төгрөгийн өртөгтэйгөөр санхүүжүүлэн ашиглалтад оруулсан.

Манай төсөл нь худалдаа үйлчилгээний барилгуудыг иж бүрнээр нь төлөвлөж, авто зам, ногоон байгууламжийг гэр хорооллын бүсэд нэмэгдүүлэн, хотын эдийн засаг, дэд бүтцийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулахын зэрэгцээ эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Тус компанийн байгаль орчны зөвлөх компаниар ажилладаг, Байгаль Орчны Нөлөөллийн Нарийвчилсан Үнэлгээний “Экотайкүүн” ХХК нь гэрээний дагуу Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн 2024 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-г зохих арга зүйн хүрээнд боловсруулан Байгаль Орчин Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яамаар батлуулсан.

Энэ төлөвлөгөөг боловсруулахад дадлага туршлагатай мэргэжлийн баг хамт олон ажилласан ба үйл ажиллагаа явуулах хугацаанд гарч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээний зөвлөмж болон санхүүгийн тооцоог гаргасан.

Бид өгсөн зөвлөмж, төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг хугацаанд нь зохион байгуулж, биелэлт, үр дүнг тооцон ажилласан.

“Да хүрээ трейд” ХХК нь Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төслийн дагуу 2024 оны 9 сарын 10-ны өдөр Нийслэлийн ерөнхий архитектор Ч.Төгсдэлгэрийн баталсан 2024/00-609 дугаартай авто зогсоолын барилгын “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-ыг хэрэгжүүлэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэж байна.

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр:

“ДА ХҮРЭЭ ТРЕЙД” ХХК

1.2 Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл:

Авто техникийн худалдаа, үйлчилгээ

1.3 Аж ахуйн нэгжийн харьяаллын хаяг:

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 9-р хороо, Шархад-55

1.4 Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар: 9011042117

1.5 Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг:

Ц.Алимаа, 99110570, da_khuree@mail.mn

1.6 Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг:

Б.Мөнхчулуун, 99075239, ecotycoon88@gmail.com

1.7 Орон нутагтай газар эзэмшлийн тухай хийсэн гэрээний огноо, баталсан хуулийн этгээдийн нэр, албан тушаал, байгууллага:

Нийслэлийн Газрын албаны 2017.01.12-ны өдрийн 000318843 тоот газар эзэмших гэрчилгээ (15 жил)

1.8 Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд

2021.11.11-ны өдөр №13/5337, Монгол Улсын Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам /хуучнаар/

1.9 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд

2021.11.11-ний өдөр №13/5337, Монгол Улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам

2. Төслийн ерөнхий мэдээлэл

2.1 Төслийн нэр:

Авто техникийн худалдаа үйлчилгээний “Да хүрээ” цогцолбор

2.2 Төслийн байршил:

Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг, 9-р хороо, Шархад-55

2.3 Төслийн талбайн газар зүйн солбицол:

| Дугаар | Уртраг | Өргөрөг |
|--------|----------------|---------------|
| 1 | 106°59'50.65"E | 47°55'47.48"N |
| 2 | 106°59'57.83"E | 47°55'49.67"N |
| 3 | 106°59'56.74"E | 47°55'51.72"N |
| 4 | 107° 0'2.63"E | 47°55'53.45"N |
| 5 | 107° 0'14.55"E | 47°55'44.80"N |
| 6 | 107° 0'9.81"E | 47°55'40.92"N |
| 7 | 106°59'54.84"E | 47°55'36.89"N |

2.4. Төслийн төрөл, ангилал:

Уг төсөл нь Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тухай хуулийн хавсралтад зааснаар үйлчилгээний салбарын төсөлд хамаарна.

2.5. Төслийн зорилго ач холбогдол:

Гэр хороололд хийгдэх хөрөнгө оруулалт нэмэгдэж, хотын эдийн засаг, дэд бүтцийн хөгжилд бодитой хувь нэмэр болохын зэрэгцээ газар ашиглалт болон гудамж, замын сүлжээ сайжирч цэцэрлэгжилт, ногоон байгууламж нэмэгдэж, гэр хорооллын болон хөрс, агаарын бохирдол буурч, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл сайжран ажлын байр нэмэгдэх олон талын ач холбогдолтой юм.

2.6. Төслийн хүчин чадал, техник технологи:

“Да хүрээ трейд” ХХК-ийн авто худалдаа үйлчилгээний цогцолборыг нийт 65143 м2 талбайд барьж, байгуулахаар хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулан зарим ажлыг эхлүүлсэн. Энэхүү цогцолбор нь:

- Авто худалдааны төв,
- Авто сэлбэгийн төв
- Оффис
- Авто засвар үйлчилгээний төв /авто угаалга/
- Авто оношлогооны төв
- Сургалт, соёл олон нийтийн төв /зочид буудал, зоогийн газар, саун, бассейн, фитнес төв, сургалтын төв, хурлын танхим/-өөс бүрдэнэ.

2.7. Авто техникийн худалдаа үйлчилгээний “Да хүрээ” цогцолборын зураг.



Црээдүйгээ
хүлээх биш бүтээ...



БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР
Ч.ТӨГСДЭЛГЭР

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

2024 оны 09 сарын 10 өдөр

Дугаар: 2024/00-609

СТА5795
9077243

Улаанбаатар хот

| | | |
|---|---|--|
| 1 | Газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ, үндэслэл | Нийслэлийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/24 дүгээр захирамжтай, 1332003025 дүгээр нэгж талбартай, Баянзүрх дүүргийн 9 дүгээр хорооны нутаг дэвсгэрт, Шар хад-2 /13281/ бүсчлэлд, Эмнэлэгийн 4 дүгээр гудамжны 2 тоот хаягтай “Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор /Худалдаа үйлчилгээ” зориулалтаар эзэмшүүлсэн 6.507 га газрыг үндэслэв. |
| 2 | Барилга байгууламжийн нэр, зориулалт | Да хүрээ трейд ХХК Авто зогсоолын барилга |
| 3 | Барилгажих талбайн хэмжээ, хүчин чадал (Тэнхлэг) | 44.4x26.4 метр хэмжээтэй; Тагт, консоль, довжоо болон рампыг эдэлбэр газарт, төлөвлөлтийн хязгаарт багтаан нормоор тооцон төлөвлөнө. |
| 4 | Барилгын төрөл, давхрын тоо | Тухайлсан зураг төсөлтэй (зоорьтой) 4 хүртэл давхар |
| 5 | Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө | Улаанбаатар хотын төлөвлөлтийн зүүн бүсийн 17 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Орон сууцны бүс |
| 6 | Эдэлбэр газрын талбай: | 65070.0 м ² |
| | - Барилгажих талбай | 1172.1 м ² (ХБТХууль 12.8) |
| | - Ногоон байгууламж, гадна тохижилт төлөвлөх талбай | Эдэлбэр газрын 20%-аас доошгүй талбай (ХБТХууль 12.6.3) |
| | - Тоглоомын талбай, амрах талбай | Эдэлбэр газрын 20%-аас доошгүй талбай (ХБТХууль 12.8, 12.6.3) |
| 6 | - Авто зогсоол | БНБД 30-01-04-н заавал мөрдөх 14 дүгээр хавсралтад зааснаар (ХБТХууль 12.6.3). - Цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх цэгийг нийт зогсоолын хүчин чадлаас хамааруулан 3%-д төлөвлөнө. - Унадаг дугуйн зам, зогсоол төлөвлөх. - Авто замын төлөвлөлтийг орчны байдал, төлөвлөлттэй уялдуулан хорооллын авто замтай холбох, орц гарцыг нэгтгэн төлөвлөх. |
| 7 | Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтод тавигдах шаардлага | - “Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах буулгах журам”-ын 4.1-т зааснаар төлөвлөн загвар зурагт хийц, загварыг тусгана. - Гудамж замын улаан шугам, талбайн тохижилт, зам талбайд гэрэлтүүлэг хийж, явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүйгээр онцгой нөхцөлд ашиглах орц гарц төлөвлөнө. - Хяналтын камер төлөвлөх, зөвшөөрөлгүй хашаа барихгүй байна. - Зөвшөөрөлгүй хашаа барихгүй байх, барилгын түр хашааны өндөр 3 метр, хамгаалалтын торны өндөр 2 метр байна. - Орчинтой уялдуулж ногоон байгууламж болон авто зогсоол талбайн тохижилтын зургийг иж бүрэн боловсруулна. - Хөрш зэргэлдээ эдэлбэр газар, барилга байгууламжаас барилга хоорондын гал тусгаарлах хамгаалалтын зай нормативыг мөрдөнө. |
| | | - Гадна тохижилтыг орчны барилга байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар төлөвлөнө. |


ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН
СТАНДАРТЫН ГАЗАР



ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛЗА

2024 оны 09-р сарын 10 өдөр

ТӨСВИЙН АЖЛААНЫ ӨНГӨ



БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Манай компани авто техникийн худалдаа, үйлчилгээ эрхлэхийн зэрэгцээ нийгмийн хариуцлагаа ухамсарлан байгаль орчноо хамгаалах үйлсэд өөрсдийн хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

Авто техникийн худалдаа үйлчилгээний цогцолборын үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах хэмжээг тодорхойлж, түүнд шаардагдах хөрөнгө, зардлыг төлөвлөх зорилтын хүрээнд компанийн ус, цахилгаан эрчим хүчийг хэмнэх, үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, хаягдлыг дахин боловсруулах, агаар хөрсний бохирдол үүсгэхгүй байх, мөн байгаль орчны менежментийг тогтолцоог бий болгох чиглэлээр тодорхой, үр дүнтэй ажлуудыг төлөвлөсөн.

“Да хүрээ трейд” ХХК-аас 2024 онд байгаль орчин хамгаалах чиглэлээр хийгдэх ажлууд, төсөв хөрөнгийг үйл ажиллагааны зардалд тусган дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан.

Нэг . СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Да хүрээ трейд” ХХК нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг үйл ажиллагааны зардалд тусган, түүний зарцуулалтад нь хяналт тавьж ажиллалаа.

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДЛЫН ТӨСӨВ

| № | Ажлын чиглэл | 2024 оны төсөвт зардал /сая төгрөг/ |
|---|--|--|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 13.1 сая |
| 2 | Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 3.0 сая |
| 3 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 0.4 сая |
| 4 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 17.8 сая |
| 5 | Төслийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр | 0.5 сая |
| | Нийт | 34.8 сая |

1.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр:

МУ-ын Агаарын тухай хууль болон түүнтэй холбогдох бусад эрх зүйн актуудыг мөрдлөг болгон агаар орчинд нөлөөлөх сөрөг байдлыг бууруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

1.1.1. Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйл, түрээсийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.5. дахь заалт, агаарын чанар техникийн ерөнхий шаардлага BNS4585:2016-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор шаардлагагүй тохиолдолд машиныг асаалттай тавихгүй байх талаарх, авто машиндаа тортог шүүгч фильтр суурилуулах талаар санамж, зааварчилгааг түрээслэгч, үйлчлүүлэгч нарт өдөрт 5-аас доошгүй удаа, байгаль орчныг хамгаалах 9 төрлийн санамжийг радио узелиэр тодорхой давтамжтайгаар, “Шаардлага”, “Мэдэгдэх хуудас”-аар 4 удаа тус тус хүргүүлж ажилласан. Энэ хугацаанд автомашины хаягдал хийнээс агаарын орчин бохирдох асуудал 30%-аар буурсан. Мэдээлэл, санамж зөвлөмжийг сурталчлах ажилд **275 мянган** төгрөг зарцуулсан байна.

- 1.1.2. Хамтран ажиллах гэрээний дагуу мэргэжлийн байгууллага “Экотайкүүн” ХХК-аар орчны болон ажлын байрны 2 цэгт агаарын чанарын шинжилгээ хийлгэж, өгсөн заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 1.1.3. Ажил үйлчилгээ эрхлэх, барилга байгууламж засварлах үед гарах тоос агаар орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол хийж, худалдааны төвийн хэмжээнд зам талбай, ногоон байгууламжийн усалгааг 5 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд сард 2-оос доошгүй удаа хийж хэвшсэн. Тухайлбал, усалгаанд зориулан автомашины шатахуун, ажилчдын цалин, усны хэрэглээ зэрэгт нийт **2,5** сая төгрөгийг зарцуулсан.
- 1.1.4. Дулааны эх үүсвэр гаргадаг хог хаягдлыг устгах зорилгоор шатамхай материалыг ил задгай шатаахыг худалдааны төвийн хэмжээнд бүрэн хориглож, гал гарсан үед шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээний “Гал унтраах шуурхай төлөвлөгөө”-г дүүргийн Онцгой байдлын хэлтсээр баталгаажуулж, урьдчилан сэргийлэх сургалтыг хамтран 3 удаа зохион байгуулсан. Галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр худалдааны төвийн задгай талбайн 23 байршилд гал командын цэг, худалдаа үйлчилгээний байранд галын дохиолол, утаа мэдрэгч, галын хорыг байрлуулж, гал унтраах багаж хэрэгслүүдийн нөөц бүрдүүлэлтийг байнга шалгаж, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

1.2 Хөрсөн бүрхэвч болон ургамалан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын чиглэлээр:

- 1.2.1 Тус худалдааны төвд “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хууль, MNS 5914:2008 “Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт”, “Газрын тухай” хууль. 50 дугаар зүйлд заасны дагуу 10 цэгт ногоон байгууламжтай болсон бөгөөд ногоон байгууламжуудад тусгаарлах хашаа, хайсыг 150м.кв талбайд шинэчлэн барьж, өнгө үзэмжийг сайжруулан, хүн техникийн үйл ажиллагаанд өртөхөөс сэргийлж, нийт **3** сая төгрөг зарцуулсан.
- 1.2.2 Хөрс болон ургамлыг хогийн ургамал болон хортон шавжаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд ахуйн шавж, мэрэгчийн устгал, ариутгал, халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагаар болон өөрсдийн хүчээр зохион байгуулж, энэ хугацаанд **5** сая төгрөгийг зарцуулсан. Компанийн хэмжээнд шарилж, хөл газрын ургамлын тархалтыг бууруулах ажлыг тогтмол хийж, дулааны улиралд 7 хоног бүр цэвэрлэж хэвшсэн.
- 1.2.3 Дулааны улиралд хур тунадасны хэмжээ ихтэй байсан хэдий ч хөрс, ургамал хуурайшиж гандахаас сэргийлэн ногоон байгууламжийн усалгааг тогтоосон хуваарийн дагуу хийдэг ба энэ онд 36 удаагийн усалгаа, арчилгаа, үйлчилгээнд **4** сая орчим төгрөгийг зарцуулсан байна.

1.3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажлын чиглэлээр:

Автомашин, бусад техник хэрэгсэлтэй холбоотойгоор агаарт хаягдах тоос болон машин механизмуудын утаа, ахуйн хог хаягдал, шатах тослох материал хөрсөнд хаягдах, нэвчих зэрэг нь хөрсний бохирдолтыг нэмэгдүүлдэг, тэдгээрийн эх үүсвэр болдог тул тус компанийн эзэмшил газрын 95 хувийг хатуу хучилттай /бетон, асфальт, эко хавтан/ болгосон ба 10 орчим хувийг нь ногоон байгууламжтай болгон, жил бүр нөхөн сэргээлт, мод зүлэг тарих, тохижилтын ажлыг үе шаттайгаар хийж байна.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй уялдуулан шилмүүст мод түлхүү тарих, барилга байгууламж орчмын 30%-ийг ногоон байгууламжтай болгох зорилт дэвшүүлэн иргэд, үйлчлүүлэгчдийн амрах орчин нөхцөлийг бий болгох зорилгоор 2024 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Ногоон байгууламжтай талбайнуудыг тусгаарласан хашаа, хайсыг 325 метр газарт шинээр татсан.
- Хавар, намрын улиралд хөрсийг тарилтад бэлтгэн сийрүүлэх, зориулалтын бордоогоор бордох, усалгааны асуудлыг тухай бүр нь шийдвэрлэсэн.
- Худалдааны төвийн гадна болон дотор нийт 1686,1 м² талбайд ногоон байгууламжийг өмнөх оноос 50%-аар нэмэгдүүлэн, шинээр шилмүүст мод 100ш, навчит мод 150ш, бут 250ш, зүлэг 215м² талбайд 100кг, нэг наст цэцэг 60 уут нийт 1248 ширхэг шар хуайс, 41 мод, цэцэг, зүлгийн үрийг худалдан авч тарин, усалгаа арчилгааг технологийн дагуу хийсэн ба нийт **13,1 сая** төгрөгийг зарцуулсан. Өнөөдрийн байдлаар 8 төрлийн 1868 ширхэг бут, 134 ширхэг хайрцагтай, 8860 шар хуайс, 118 тооны модтой байна.

2. Хөрсний элэгдэл болон сул шороон хөрс бүхий газрын эзлэх хувийг бууруулж үйлчилгээний таатай орчин бүрдүүлэх ажлын хүрээнд зам талбайн засвар үйлчилгээ, бороо, үерийн усны суваг зэрэгт засвар, үйлчилгээ болон тохижилтыг хийсэн. Үүнд:

- Худалдааны төвийн худалдах автомашины зогсоол, автомашин болон явган хүний замууд 100 хувь бетон, асфальтаар хучигдаж, орчны тоосжилт, хөрсний эвдрэл гэмтэл, бохирдлоос бүрэн хамгаалагдсан болно. 2024 онд өөрийн эзэмшлийн 433м² талбайд зам талбайн нөхөөс, 605,22м² талбайд шинээр явган зам, 45ш авто замын бордюр сольж, нийт **20** гаруй сая төгрөг зарцуулсан.
- Үерийн ус зайлуулах инженерийн шугам, худагт засвар хийх, хур тунадаснаас үүссэн усыг 3 тонны 2, 5 тонны 1 саванд тухай бүр хуримтлуулан хадгалж, үйлчилгээний байрнуудын дээврийн усны хаялагд ус нөөцлөх зориулалт бүхий тус бүр 400 литрийн багтаамжтай 6ш савыг 3 цэгт байршуулан ногоон байгууламжийн усалгаа арчилгаанд ашиглаж байна.
- Шатах тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх, байгаль орчин, газрын хөрсийг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулж, авто техникийн шингэн бодис, материалыг задгай хэлбэрээр зарж борлуулах, хадгалах, тээвэрлэхийг бүрэн хориглосон. Тос, тосолгооны материал борлуулдаг 15 түрээслэгч, сэлбэг хэрэгсэл худалдан борлуулдаг 150 гаруй бизнес эрхлэгчийг бүртгэлжүүлж, тос асгаж бохирдуулахаас сэргийлэх, орчны эрүүл ахуйг хангах мэдэгдэл хүргүүлж, зам талбайг давхар хамгаалсан хавтан /резин/ байрлуулснаар авто техникийн тос, зам талбайд нэвчих, эвдрэл үүсэхээс сэргийлж чадсан.
- Газар ашиглалтын өнөөгийн төлөв байдал, газрын эвдрэл, доройтол, хөрс болон ургамалан нөмрөгийн бүтэц, ашиглалтын түвшнийг тодорхойлох зорилгоор байгаль орчны үнэлгээний “Эко цогц шийдэл” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны үнэлгээ”-г шинэчлэн хийсэн.
- Хогийг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх, хөрсний бүтэц өөрчлөгдөж байгаатай уялдуулан байгалийн ургамлан бүрхэвчийг нэмэгдүүлэх чиглэлээр заавар зөвлөгөө өгсөн. Шатах тослох материал асгахгүй байх зөвлөмжийг боловсруулан хөрс, ургамал хамгаалах самбар 15 ширхэг, хөрс бохирдуулахгүй байх анхааруулга 17 ширхгийг тус тус байршуулан, олон нийтэд сурталчилсан.

Хоёр. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮРЭЭНД

- 2.1. Хүний буруутай үйл ажиллагаанаас гал түймэр гарахаас сэргийлэн Худалдааны төвд үйл ажиллагаа явуулж буй 653 түрээслэгчийн ажлын байранд “Галын аюулгүй байдал”-ын үзлэг шалгалтыг 2024 онд 2 үе шаттайгаар зохион байгуулж ажилласан бөгөөд нийт галлагаа хийдэг 44 нэгжээс 18 нэгжийг цахилгаан халаалтад шилжүүлж 26 нэгж нь зориулалтын шахмал түлшээр ердийн галлагаатай хийж байна.

- 2.2. Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсээс Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг хийж, компанийн “Галын дүгнэлт”-ийг журмын дагуу гаргаж өгсөн бөгөөд Налайх дүүргийн Уул уурхайн аврах ангийн штабын дарга ахмад Б.Батзоригоор “ГАУС, гал унтраагуурыг ажиллуулах арга” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулуулж, дотоод нөөц боломжоор гал унтраах, газар хөдлөлтийн үед ажиллах дадлага сургуулийг зохион байгуулж явуулан тухай бүрд БЗД-ийн ОБХ, 9-р хороонд тайлагнаж ажилласан.
- 2.3. Худалдааны төвийн хэмжээнд тамхи татах 3 цэгийг тохижуулан, төхөөрөмжилж ашигладаг бөгөөд зориулалтын бус газар тамхи татахгүй байх санамжийг 164 цэгт, анхааруулга зөвлөмжийг өдөр бүр 2-3 удаагийн давтамжтайгаар радио узелиэр нэвтрүүлж, дотоод хяналт, хамгаалалтын бүрэлдэхүүн галын эргүүлийн үйл ажиллагааг өдөр тутам хийж галын аюулаас урьдчилан сэргийлж ажилласан.
- 2.4. 2024 онд Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа алдагдсан, осол аваар гарсан тохиолдол бүртгэгдээгүй бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажилчдад өдөр тутам, түрээслэгч иргэдэд сар бүр, гэрээт засвар үйлчилгээний ажилтнуудад тухай бүр танилцуулан, мөрдүүлж ажилласан.
- 2.5. Худалдааны төвийн байрнуудын дээвэр, хаалгануудыг шинэчлэн сольж, цонхны дулаалгыг бүрэн хийж, өвлийн улиралд ажиллах цагийн хуваарийг 9.00-18.00 цаг болгон худалдааны төвийн тарах цагийг 30 минутаар урагшлуулснаар эрчим хүчийг тодорхой хэмжээнд хэмнэж байна.

Гурав. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ЧИГЛЭЛЭЭР

- 3.1. Худалдааны төвөөр үйлчлүүлж буй иргэд, үйлчлүүлэгч, бизнес эрхлэгчдийн тав тух, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхийн тулд Монгол Улсын “Хог хаягдлын тухай хууль”, “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам” болон компанийн “Ажил үйлчилгээний журам”-ыг мөрдлөг болгон хог хаягдлын менежментийг сайжруулахад анхаарч ажилласан.
- 3.2. Баянзүрх дүүргийн нийтлэг үйлчилгээний IV газартай хог тээврийн гэрээ “Үйлст Мандал” ХХК-тай хог хаягдал тээвэрлэх гэрээг шинээр байгуулан, гэрээний дагуу хатуу хог хаягдлыг төвлөрсөн 3 цэгээс долоо хоног бүрийн Даваа гарагт 2-4 рейсээр зориулалтын битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлүүлэн төлбөр, хураамж болох 19 сая төгрөгийг төлсөн. Бусад хог тээвэртэй холбоотой, сургалт зохион байгуулалтын асуудлыг тус компани бүрэн хариуцаж ажилладаг.
- 3.3. Хатуу хог хаягдлыг 5 төрөл /хуванцар сав, хаягдал цаасан хайрцаг, лааз, төмөр, хагдал батарей/-өөр ангилан ялгаж хоёрдогч түүхий эд авдаг хувь хүн /Л.Давааням/, байгууллага /“ЭС И ЭЛ СМАРТ СОЛЮШН” ХХК/-тай гэрээгээр хамтран ажиллаж нийлүүлдэг. Аюултай хог хаягдал болох ашиглагдсан зай, батарейг ил задгай хаягдахаас сэргийлж худалдааны төвд зай борлуулдаг хүнсний дэлгүүрүүд, батарей сольдог хүмүүст санамж бичиг танилцуулж, хаягдал зай цуглуулах савыг 6 газарт байрлуулсан ба хуванцар сав, гялгар уут, цаас зэргийг эх үүсвэр дээр нь ангилж, цаасан хайрцгийг 20 удаа, гялгар уут, хуванцар савыг 3 удаа хоёрдогч түүхий эдийг авах цэгт тушаасан.
- 3.4. Дараах байдлаар ажилласан:
 - Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалаар баталсан “Энгийн хог хаягдлыг ангилан, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-ын дагуу хогийг ангилан ялгаж хаях боломж бүхий 5 төрлийн 98 ширхэг хогийн савыг засварлаж, шинээр үйлчлүүлэгчдэд хүрэлцэхүйцээр байрлуулсан.

- Худалдааны төв дэх хатуу хог хаягдлыг агаар, ус чийг, салхинаас бүрэн хамгаалах, түр хураан хадгалах савны бүрэн бүтэн байдлыг хангаж, хоёрдогч түүхий эдийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах зорилгоор нэгдсэн 3-н хогийн цэгийг сайжруулж шинэчилсэн.
- “Голден Эко” ХХК-тай бохир тээвэрлэлтийн гэрээ байгуулж, төвлөрсөн 4 цэгээс Даваа гараг бүр 5-8 рейсээр зориулалтын цэгт тээвэрлүүлж нийт 240 удаа соруулж **10 сая** төгрөгийг зарцуулсан.
- Худалдааны төвийн хэмжээнд бүх нийтийн их цэвэрлэгээг 6 удаа нийт 500 гаруй бизнес эрхлэгч, компанийн 60 гаруй ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, худалдааны төвийн ойр орчмын болон нийтийн эзэмшлийн 1,5 га зам талбай, худалдааны төв доторх 6,5 га зам талбай, ногоон байгууламж, үерийн хамгаалалт, ус нэвтрүүлэх хоолой, гуу жалганд хуримтлагдсан ахуйн гаралтай хог хаягдлыг цэвэрлэн худалдааны төвийн төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлж гэрээт компаниар тээвэрлүүлсэн.
- Компанийн жилийн ажлын төлөвлөгөө, эрүүл ахуйн чиглэлээр хийгдэх ажлын хүрээнд хөрсний бохирдлоос сэргийлэх, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөл бололцоог хангах зорилгоор нийт 3500 м2 талбайд гэрээт компаниар 2 удаа, өөрсдийн нөөц бололцоогоор 5 удаа ариутгал халдваргүйжүүлэлт /гипохлорид, жавелин уусмал, тамир эм/-ийг хийсэн.

Дөрөв. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

- 4.1 Авто техникийн худалдаа үйлчилгээний “Да хүрээ” цогцолборыг барих явцад хүрээлэн буй орчин, байгаль экологийн тэнцвэрт байдалд үзүүлэх зайлшгүй болон болзошгүй сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг хянан шинжлэх мониторинг хийх ажлыг 2015 оноос “Экотайкүүн” ХХК-тай хамтран хэрэгжүүлж, арга зүйн зөвлөгөө, мэдээллийг тогтмол авч ажиллаж байна.
- 4.2 Компани нь дэд бүтцэд холбогдоогүй бөгөөд 2005 оны 08 дугаар сард гадна цэвэр усны шугамын угсралтын ажлыг Ус Сувгийн Удирдах Газрын №166/05 дугаар техникийн нөхцөлийг үндэслэн “ДОБА” ХХК-тай гэрээ байгуулан Шар хадны 17 дугаар хорооны гэр хорооллын төв замын хойд талын цэвэр усны шугам /худаг/-аас шинээр худаг хийж, холбон цэвэр ус ашиглаж эхэлсэн. Монгол Улсын Усны тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартыг удирдлага болгон ажиллаж Улаанбаатар хотын УСУГ-тай 2014 онд байгуулсан “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах” гэрээг мөрдөн жил бүр дүгнэн ажилладаг бөгөөд холбогдох төлбөр тооцоог тухай бүрд нь барагдуулж ажилладаг. Компанийн цэвэр усны жилийн хэрэглээ 3061 шоо метр буюу өдөрт дунджаар 0.8 шоо метр байдаг. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 4 төрлийн шинжилгээг “Экотайкүүн” ХХК-тай хамтран мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн зохих заавар зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
- 4.3 MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмжийн дагуу “Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн шинжилгээ”, “Ундны усны бүрэн шинжилгээ”, “Ундны усан дахь хүнд металлын агууламж” шинжилгээнүүдийг 4,9-р сард “Инженер геодези” ХХК-ний итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн.
- 4.4 Тухайлбал: Стандарт, хэмжил зүйн газрын Нийслэлийн лабораторийн нян судлалын лабораторид ундны усны бүрэн шинжилгээ, ундны усны эмгэг төрүүлэгч бактерийн тоо, ундны усан дахь хүнд металлын агууламж зэргийг шинжлүүлэхэд, ундны усны эрүүл ахуйн шаардлагад нийцсэн гэж дүгнэлт гарсан.

| Дээжийн дугаар | Шинжилгээний аргын стандарт | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж | Шаардлага | Шинжилгээний дүн |
|-------------------|-----------------------------|---|-------------------|------------------|
| 3516 | MNS ISO 6222:1998 | ББЕТ | 1 мл-т 100 | 1 мл-т 118 |
| | MNS ISO 19250:2017 | Salmonella spp | 25 мл-т илрэхгүй | 25 мл-т илрээгүй |
| | MNS ISO 9308-1:1998 | Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас, шүүлтүүр/ | 100 мл-т илрэхгүй | 100мл-т илрээгүй |
| | MNS 4430:2005 | Нийт төмөр | <0,30 мг/л | 0,01 |
| | MNS ISO 7890-3:2001 | Нитрат | <50,0 мг/л | 1,169 |
| | MNS 4431:2005 | Нитрит | <1,0 мг/л | 0,003 |
| | MNS ISO 10523:2001 | pH | 6.50-8.50 | 7,05 |
| | MNS 6271:2011 | Сульфат | <500,0 мг/л | 3,03 |
| | MNS ISO 6878:2001 | Фосфат | <3,5 мг/л | 0,0 |
| | MNS 6272:2011 | Фтор | 0,70-1,50 мг/л | 0,09 |
| | MNS ISO 6059:2005 | Хатуулаг | <7,0 мг,экв/л | 0,64 |
| | MNS 4424:2005 | Хлорид | <350,0 мг/л | 7,79 |
| | MNS ISO 8288-1999 | Зэс | <2,0 мг/л | <0,007 |
| | MNS ISO 8288-1999 | Кадми | - | <0,0008 |
| | MNS ISO 8288-1999 | Хар тунгалаг | <0,01 мг/л | <0,0008 |
| MNS ISO 8288-1999 | Цайр | <5,0 мг/л | 0,0 | |

- “Эко цогц шийдэл” ХХК-ийн мэргэжилтнүүд худалдааны төвийн дотор 1, гадна 3 цэгээс хөрсний эрүүл ахуйн болон хүнд металлын шинжилгээ авсан. Шинжилгээний дүнд MNS 5850:2008 ерөнхий стандартаас давсан хүнд металлын бохирдол илрээгүй боловч элсэрхэг хөрсөнд агуулагдах молибден, хүнцлийн агууламж ялимгүй их тодорхойлогдсон. Хүнцлийн агууламж 0-10 см дахь гүнд 5-аас бага, 10-20 см дахь гүнд 8.57 мг/кг буюу хөрсний өнгөн хэсгээс гүн рүү агууламж ихэссэн байгаа нь хүний үйл ажиллагаанаас бус тухайн хөрс үүсгэгч эрдэс чулуулгийн агууламжаас хамаарсан гэж дүгнэсэн.
- Хөрсний бохирдлын нөлөөллийг үнэлэх зорилгоор худалдааны төвийн гаднах талбайн 3 цэгээс дээж авч хөрсний чанарын ерөнхий стандарт үзүүлэлттэй харьцуулан бохирдлын түвшнийг тодорхойлоход MNS 5850:2008 стандартаас давсан үзүүлэлт тодорхойлогдоогүй нь худалдааны төвийн болон нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ ариутгал шаардлага хангахуйц түвшинд байна гэж үзэж байна.
- Хөрсний бохирдлоос сэргийлэх ажлын хүрээнд худалдааны төвд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд сар бүр хяналт тавин, ил задгай бие засах, хог хаях зөрчлүүдийг арилгах зорилгоор 500 орчим нэгжид тараах материал, тос тослох материал асгаж орчноо бохирдуулсан 60 нэгжид мэдэгдэх хуудас өгч, радио узелээр сэрэмжлүүлж, зөрчлийг тухай бүр нь арилгуулан ажилласнаар өмнөх онтой харьцуулахад орчны болон хөрсний бохирдол, ил задгай хог хаях зөрчлүүд өмнөх онтой харьцуулахад тодорхой хувиар буурсан.
- Хөрсний нянгийн бохирдлын эх үүсвэр нь ил задгай хог хаях, гэр хорооллын нүхэн жорлон, шингэн угаадас хаягдлаас үүсэж байдаг бөгөөд тус худалдааны төвийн

бохирын систем, бохир тээвэрлэлтийг мэргэжлийн байгууллагад гэрээгээр хариуцуулан өгч, түрээслэгч, үйлчлүүлэгч нарын зүгээс ил задгай бохир, угаадас асгах, орчныг бохирдуулахгүй байхад хяналт тавьж ажиллаж байна. Хөрсөн дахь органик бохирдуулагч буюу микробиологийн шинжилгээний дээжийг “Хан лаб” ХХК-ийн лабораторид шинжлүүлсэн.

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ /Гүн 0-10 см/

| № | Үзүүлэлт | Шинжилгээний стандарт | Нэгж | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Шинжилгээний дүн |
|---|---|-----------------------|-------|--------------------------|---------------------|
| 1 | Бактерийн ерөнхий тоо | MNS 6341:2012 | 1 г-д | - | 2.2*10 ⁴ |
| 2 | Калиформ гэдэсний бүлгийн нянгийн таньц | MNS 5367:2004 | 1 г-д | илрэхгүй | илрээгүй |
| 3 | Клостридиум пеифрингенсийн таньц | MNS 6341:2012 | 1 г-д | илрэхгүй | илрээгүй |

Хүснэгт 2. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ /Гүн 10-20 см/

| № | Үзүүлэлт | Шинжилгээний стандарт | Нэгж | Зөвшөөрөгдөх дээд хэмжээ | Шинжилгээний дүн |
|---|---|-----------------------|-------|--------------------------|---------------------|
| 1 | Бактерийн ерөнхий тоо | MNS 6341:2012 | 1 г-д | - | 1.9*10 ⁵ |
| 2 | Калиформ гэдэсний бүлгийн нянгийн таньц | MNS 5367:2004 | 1 г-д | илрэхгүй | илрээгүй |
| 3 | Клостридиум пеифрингенсийн таньц | MNS 6341:2012 | 1 г-д | илрэхгүй | илрээгүй |

Шинжилгээний дүгнэлтээр хөрсөн дэх нийт бактерийн тоо дундаж хэмжээнд, гэдэсний бүлгийн нянгийн таньц, клостридиум пеифрингенсийн таньц илрээгүй байгаа нь хөрс микробиологийн бохирдолгүйг илтгэж байна.

Тав. ДҮГНЭЛТ

- 5.1. Тус компанийн “Авто худалдаа, үйлчилгээний цогцолбор” төслийн 2022 оноос 2024 оны хооронд “Байгаль орчны менежмент”-ийн чиглэлээр хийгдэх ажлын төлөвлөгөө, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол, тайланг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулан, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар баталгаажуулан, биелэлт, үр дүнг тооцон, холбогдох хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь тайлагнаж ажилласан.
- 5.2. Дээрх төлөвлөгөө, эрх бүхий алба хаагчийн үүрэг, зөвлөмжийн дагуу байгаль орчныг хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэж, импортын автомашин, тэдгээрийг сэлбэг, хэрэгслийн худалдаа үйлчилгээг стандарт, дүрэм журмын дагуу хэвийн явагдаж байна.
- 5.3. Энэ онд тус худалдааны төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, сэргээгдэх эрчим хүч ашиглах, тоосжилт, агаарын бохирдлыг багасгах, бууруулах ажилд болон зар сурталчилгаанд нийт **144.5 сая** төгрөгийг зарцуулсан.
- 5.4. Төсөл хэрэгжиж байгаа “Да хүрээ” худалдааны төв нь байгаль орчныг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүн, холбогдох байгууллагуудын хийсэн судалгаа, шинжилгээний дүгнэлтээр:
 - Агаарын чанар хэвийн;

- Дуу чимээний бохирдол бага зэрэг;
 - Хөрсний бохирдол маш бага;
 - Мод, ургамлын тархац хэвийн гэсэн байна
- 5.5. Энэхүү тайланг “Да хүрээ трейд” ХХК-ийн байгаль орчны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, түүний сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ажлыг хариуцсан ажилтан тайлагнасан болно.
- 5.6. Цаашид хууль тогтоомж, мөрдөж буй дүрэм журам, стандарт шаардлагыг компанийн хэмжээнд хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зардлыг төлөвлөсөн ажлын дагуу зарцуулах, цэцэрлэгжилт, ногоон байгууламжийг жил бүр өсгөн нэмэгдүүлэх, гэр хорооллын болон худалдааны төвийн газар нутгийн хөрс, агаарын бохирдлыг бууруулах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах нөхцөл сайжруулахад мэргэжлийн байгууллагын туслалцаа, хамтын ажиллагааг түшиглэн ажиллахад боломжтой гэдгээ илэрхийлье

“ДА ХҮРЭЭ ТРЕЙД” ХХК

2024 оны 10 дугаар сарын 25

“ЭС И ЭС ЭЛ СМАРТ СОЛЮШН” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч. АГИЙМАА Ч. АГИЙМАА

БАТЛАВ

“Да хүрээ трейд” ХХК-н

ЗУХИХ-Н ДАРГА

Х. Амарзүг



ХУВАНЦАР САВ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 8 сарын 1 өдөр
хот

SESL-24/....

Улаанбаатар

Энэхүү хуванцар сав нийлүүлэх гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г

Нэг талаас, “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК (РД:6990916) /цаашид “Худалдан
авагч” гэх/, түүнийг төлөөлж *Х. Амгалан*

Нөгөө талаас,

“Да хүрээ трейд” ХХК (РД: 2063115)
/цаашид “Нийлүүлэгч” гэх/, түүнийг төлөөлж *Х. Амарзүг*
/хамтад нь “Талууд” гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан, худалдан авагчийн шаардлагыг хангахуйц РЕТ1 тэмдэглэгээ бүхий ундаа, усны хуванцар сав, бүх төрлийн лаазыг хүлээлгэж өгөх, худалдан авагч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх болон бусад харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО, ХУГАЦАА

- 2.1 1кг хуванцар савны үнэ 400 (дөрвөн зуу), цэг дээр хүлээн авах үнэ 600 (зургаан зуу) төгрөг тус тус байна.
- 2.2 Нийлүүлэгч төлбөр төлөгдсөнөөс хойш ажлын 3 хоногийн дотор и-баримтыг шивнэ.
- 2.3 **Төлбөр төлөх нөхцөл:** Хуванцар савыг хүлээлгэж өгснөөс хойш ажлын 3 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.
- 2.4 **Төлбөр төлөх данс:** Нийлүүлэгчийн тоот дансны нэртэй “.....” банкны дансаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.
- 2.5 **Гэрээний хугацаа:** Энэхүү гэрээ нь баталгаажсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.
- 2.6 Гэрээний хугацаа дуусах үед талууд ямар нэгэн санал гаргаагүй бол гэрээ дахин 1 жилээр сунгагдана.
- 2.7 Гэрээний төлбөрийг нэмэх, хасах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдэх бөгөөд зөвхөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинэ төлбөрийн нөхцөл болон дүн баталгаажна.
- 2.8 Нийлүүлэгчийн хүлээлгэж өгсөн хуванцар савнууд дунд өөр төрлийн хуванцар сав болон хэт бохирдсон хуванцар сав нь 2кг-аас хэтэрсэн тохиолдолд энэ талаар мэдээллийг Худалдан авагч нь Нийлүүлэгчид мэдэгдэж нийт хэмжээгээр хорогдолд тооцож төлбөрийг төлнө.

ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

3.1 **Нийлүүлэгчийн хүлээх үүрэг**



УЛААНБААТАР ХОТ
“ДА ХҮРЭЭ ТРЕЙД” ХХК-ИЙН
ЗАХИРАЛД
ЦАЛИМАА

БАТЛАВ:

АЖИЛТАН

Л. ДАВААНЯМ

ХАЯГДАЛ ЦААСАН ХАЙРЦАГ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 04 сарын 17 өдөр

Улаанбаатар хот

Энэхүү хаягдал цаасан хайрцаг нийлүүлэх гэрээ /цаашид “Гэрээ” гэх/-г

Нэг талаас “Да хүрээ трейд” ХХК (РД:2063115) /цаашид нийлүүлэгч гэх/, түүнийг төлөөлж ДХШ, ХАБЭА-н менежер

Нөгөө талаас /РД ОР: 73052016 /цаашид “худалдан авагч гэх”/, түүнийг төлөөлж иргэн /хамтад нь “Талууд” гэх/ нар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэхүү гэрээний зорилго нь нийлүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан хаягдал цаасан хайрцагнуудыг худалдан авагчид хүлээлгэн өгөх, Худалдан авагч нь хэлэлцэн тохирсон хөлс төлөх болон бусад харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР. ТӨЛБӨР ТООЦОО, ХУГАЦАА

2.1 Нэг тонн хаягдал цаасан хайрцагны үнэ 40,000 төгрөг /дөчин мянга/ төгрөг байна. /Дуудлагаар/

2.2 Нийлүүлэгч тал худалдан авагчид дуудлага өгсөн тохиолдолд 1-2 хоногийн дотор ирж хаягдал цаасыг ачиж авна.

2.3 Төлбөр төлөх нөхцөл: Хаягдал цаасан хайрцагийг ачиж авсан өдрөө бэлнээр кассанд тушаана.

2.4 Төлбөр төлөх данс: Нийлүүлэгчийн 5019657777 тоот Да хүрээ трейд дансны нэртэй “Хаан” банкны дансаар төлбөр тооцоог хийж гүйцэтгэнэ.

2.5 Гэрээний хугацаа: Энэхүү гэрээ баталгаажсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна.

2.6 Гэрээний хугацаа дуусах үед талууд ямар нэгэн санал гаргаагүй бол гэрээ дахин 1 жилээр сунгагдана.

2.7 Гэрээний төлбөрийг нэмэх, хасах асуудлыг талууд харилцан тохиролцож шийдэх бөгөөд зөвхөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулснаар шинэ төлбөрийн нөхцөл болон дүн баталгаажна.

ГУРАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Нийлүүлэгчийн хүлээх үүрэг

3.1.1 Нийлүүлэгч нь бүх төрлийн хаягдал цаасан хайрцаг хүлээлгэн өгнө.

3.1.2 Нийлүүлэгч цаасан хайрцагнуудыг хогийн цэгүүдээс цуглуулж, нэг байрлалд төвлөрүүлэн хураах үүрэгтэй

Батлав. Захиалагч:

“Да хүрээ трейд” ХХК

Дарга /Захирал/

[Signature]

Батлав. Гүйцэтгэгч:

“Баатарван Жаргалант” ХХК

Захирал

[Signature] / Б.Алтансүх /

**АРИУТГАЛ ХАЛДВАРГҮЙТГЭЛ, ШАВЬЖ МЭРЭГЧ УСТГАЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ**

Улаанбаатар хот

№.....

Огноо 2024-11-2

Нэг талаас “Да хүрээ” Трейд (цаашид “Захиалагч” гэнэ), нөгөө талаас “Баатарван Жаргалант ХХК (рег:5291283), тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар АҮХ-19/22/3764 (цаашид “Гүйцэтгэгч”, хамтад нь “Талууд” гэнэ) нар харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг байгуулав.

1. Ерөнхий зүйл

- 1.1. Халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх, хоргон шавьж, мэрэгчийн тархалтыг багасгаж, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор энэхүү гэрээг байгуулав.
- 1.2. Монгол Улсын Ариун цэврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 8 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн заалтууд, 17 дугаар зүйлийн 17.1.6 дахь заалт, 18 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, болон бусад хууль тогтоомжийн дагуу ариутгал халдваргүйтгэл, шавьж, мэрэгч устгалын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Энэхүү гэрээ нь 2024 оны 11 сарын 24 өдрөөс эхлэн 2025 оны 11 сарын 24 өдөр хүртэл хүчинтэй. Гэрээний хугацаа дууссан боловч талууд гэрээг дуусгавар болгох тухай нөгөө талдаа албан ёсоор мэдэгдээгүй бол гэрээг цаашид ижил хугацаа, нөхцөлтэйгээр сунгагдсанд тооцно.
- 2.2. Ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээг объектийн харилцан тохиролцсон хамрагдах нийт 2940 м2 талбайд жилд 1 удаа хийж гүйцэтгэнэ.
- 2.3. Шавьж устгалын үйлчилгээг нийт 2940 м2 талбайд жилд 1 удаа хийж гүйцэтгэнэ.
- 2.4. Мэрэгч устгалын үйлчилгээг нийт 2940 м2 талбайд жилд 1 удаа хийж гүйцэтгэнэ.

3. ГЭРЭЭНИЙ ҮНЭ


- 3.1. Ариутгал, Халдваргүйтгэл 1м2 400 төгрөгөөр, /халдваргүйтгэл хийх бодисын нэр төрлөөс хамаарна./ Нийт: 2940 м2 талбайг нийт 1.176.000 төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 3.2. Шавьжгүйтгэл 1м2 500 төгрөгөөр/ Нийт 2940 м2 талбайг нийт 1.470.000 төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 3.3. Мэрэгчгүйтгэл 1м2 500 төгрөгөөр/ Нийт 2940 м2 талбайг нийт 1.470.000 төгрөгөөр гүйцэтгэнэ.
- 3.4. Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад ажлын хэмжээ, агуулга өөрчлөгдсөн тохиолдолд хоёр тал тохиролцон зохих журмын дагуу тооцож гэрээний үнэнд өөрчлөлт оруулж болно.

4. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Захиалагч байгууллага, аж ахуйн нэгж нь ахуйн хортон шавьжийн идэвхитэй үржил, тархалтын ба халдварын үед өөрийн хүсэлтээр гэрээнээс гадуур захиалга өгч гэрээнд заасан нөхцөлүүдээр үйлчлүүлж болно.
- 4.2. Гүйцэтгэгч байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг хангалтгүй гэж үзвэл үйлчилгээтэй холбоотой санал гомдлыг гаргах эрхтэй.
- 4.3. Захиалагч тал нь шавьж, мэрэгчийн тархалтыг үйлчлэгч байгууллагын мэргэжилтнүүдэд үнэн зөвөөр мэдээлж тандалт судалгааг дэмжих гэрээнд заасан хугацаа, графикийн дагуу

25/04/2024, 15:16

GASI-LIMS



Хүнсний Аюулгүй Байдлын
Үндэсний Лавлагаа Лабораторийн
өрөнхий захирлын 2023 оны 01 сарын
02-ны өдрийн А/02 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт Маягт 00-59

**СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН
НИЙСЛЭЛИЙН ЛАБОРАТОРИ**
Улаанбаатар 14210, Сүхбаатар дүүрэг,
Чин Ван Чагдаржавын гудамж
Утас: 77775010

**ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
CERTIFICATE OF ANALYSIS**

Бүртгэлийн дугаар /Registration number/ : 24-721

Шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан газрын нэр : Дахүрээ трейд
/The name of customer's request for analysis/

Дэд лабораторийн нэр /Name of the sub laboratory/ : Нян судлалын лаборатори; Хими, хор
судлалын лаборатори

| Дээжийн тодорхойлолт /Sample description/ | | | | | |
|---|-------------------------------|---------------------------------|--|---|--|
| Дээжийн дугаар Sample number | Дээжийн нэр Name of sample | Цувралын дугаар Batch number | Үйлдвэрлэсэн улс The country of original manufacturer | Бүтээгдэхүүний хүчинтэй хугацаа Date of expiry | Дээжийн тоо хэмжээ Quantity of the sample |
| 2868 | ТУХ | | Монгол Улс | Тодорхойгүй | 2.5 л |

| Хүлээн авсан огноо Date of receipt | Шинжилгээ дууссан огноо Date of test completion | Хэвлэсэн огноо Date of issue of the report |
|---------------------------------------|--|---|
| 2024 он 04 сар 18 өдөр | 2024 он 04 сар 25 өдөр | 2024 он 04 сар 25 өдөр |

| Дээжийн дугаар Sample number | Шинжилгээний аргын стандарт Method of analysis | Шинжилсэн үзүүлэлтийн нэр, хэмжих нэгж Test parameter, unit | Шаардлага Test specification, unit | Шинжилгээний дүн Test results |
|---------------------------------|---|--|---------------------------------------|----------------------------------|
| 2868 | MNS ISO 6222:1998 | ББЕТ | 1 мл-т 100 | 1 мл-т 3 |
| | MNS ISO 19250:2017 | Salmonella spp | 25 мл-т илрэхгүй | 25 мл-т илрээгүй |
| | MNS ISO 9308-1:1998 | Халуун тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/ | 100 мл-т илрэхгүй | 100 мл-т илрээгүй |
| | MNS ISO 8288:1999 | Зэс | <2.0 мг/л | <0.007 |
| | MNS ISO 8288:1999 | Кадми | <0.003 мг/л | <0.0008 |
| | MNS ISO 8288:1999 | Хар тугалга | <0.01 мг/л | <0.0008 |
| | MNS ISO 8288:1999 | Цайр | <5.0 мг/л | 0.0 |
| | MNS 1097:2023 | Кальци | <100 мг/л | 10.26 |
| | MNS 1097:2023 | Магни | <30 мг/л | 26.51 |
| | MNS 4430:2005 | Нийт төмөр | <0.30 мг/л | 0.0 |
| | MNS ISO 7890-3:2001 | Нитрат | <50.0 мг/л | 1.41 |
| | MNS 4431:2005 | Нитрит | <1.0 мг/л | 0.0 |
| | MNS ISO 10523:2001 | pH | 6.50-8.50 | 6.86 |
| | MNS 6271:2011 | Сульфат | <500.0 мг/л | 4.83 |
| | MNS ISO 6878:2001 | Фосфат | <3.5 мг/л | 0.0 |
| | MNS 6272:2011 | Фтор | 0.70-1.50 мг/л | 0.08 |
| | MNS ISO 6059:2005 | Хатуулаг | <7.0 мг.экв/л | 2.70 |
| MNS 4424:2005 | Хлорид | <350.0 мг/л | 5.67 | |
| MNS ISO 7888:1999 | Цахилгаан дамжуулах чанар | <1.0 мСм/см | 0.079 | |


Санал тайлбар:
Opinions and interpretation



“Да хүрээ трейд” ХХК-ийн 2024 онд байгаль орчныг хамгаалахад
зарцуулсан зардал

| № | Хэрэгжүүлсэн ажил | Хугацаа | Тоо | Зардал /сая.төг/ |
|-------------|--|-------------------------|--|---------------------|
| 1 | Ногоон байгууламж | 2024.04 сараас 9 сар | 3620 м.кв | 13.1 сая |
| 2 | Зам талбайн засвар | 2024 он | 2564,2 м.кв | 20.4 сая |
| 3 | Хатуу, шингэн хог хаягдал тээвэрлэлт | 2024 он | 383 удаа | 29.0 сая |
| 4 | Агаар хөрсний бохирдлоос сэргийлэх | 2024 он | 3500 м.кв | 15.0 сая |
| 5 | Сэргээгдэх эрчим хүч ашиглах, эрчим хүч, дулааны алдагдлаас сэргийлэх чиглэлээр | 2024 он | 18 удаа | 35.3 сая |
| 6 | Галын дохиолол, хамгаалалт | 2024 он | 180 | 30.7 сая |
| 7 | Хяналт, шинжилгээ | 2024 он | Ус-2 удаа Агаар-2 удаа Хөрс-2 удаа | 1.0 сая |
| Нийт | | | | 144.5 сая |


Авто худалдааны төвийн барилга, байгууламжийн тохижилтын хэсгээс



Иргэд, үйлчлүүлэгчдийн зогсоолын хэсгээс



Иргэд үйлчлүүлэгчдэд зориулсан амралт, чөлөөт цаг өнгөрүүлэх хэсэг




Галын аюулгүй байдалтай холбоотой сургалт, дадлага явуулж байгаа зураг.



Ногоон байгууламжийн чиглэлээр хийгдсэн ажлуудаас





Зам талбайн хэсгээс



Иргэд, бизнс эрхлэгчдэд зориулсан анхааруулга, санамж



Байгаль орчны чиглэлээр иргэд үйлчлүүлэгчдэд өгдөг анхааруулга, санамжууд:

БИЗНЕС ЭРХЛЭГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ НАРЫН АНХААРАЛД

Гамшгаас хамгаалах тухай хууль болон “Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар авах зарим арга хэмжээ”-ний заалтын дагуу галын аюулаас урьдчилан сэргийлэх дараах санамжийг хүргэж байна. Үүнд:

1. Хаврын улиралд хуурайшилт ихтэй байгаа тул, ой, хээр, ил задгай газарт гал түлэхийг хориглоно.
2. Иргэн, айл, өрх бүр гал түймэр унтраах багаж, хэрэгсэл, галын хортой байх.
3. Түлсэн гал, асаасан шүдэнз, татсан тамхины гал, цог, нурмыг бүрэн унтраан, хогийг хогийн саванд хийж хэвших.
4. Машин, техникийн утааны янданг оч баригчтай болгох.
5. Ажиллаж, амьдарч байгаа орчиндоо хог шатаах, гагнуур хийж оч үсэргэх, ил задгай гал түлэх, шарилж өвс шатаахыг хориглох
6. Насанд хүрээгүй хүүхдээс чүдэнз, асаагуурыг хол байлгах.
7. Галын аюулаас урьдчилан сэргийлэх санамж зааврыг тогтмол баримталж ажиллана уу.

“ДА ХҮРЭЭ ТРЕЙД” ХХК –ИЙН ДХША

Худалдаа үйлчилгээ эрхлэгчдын анхааралд

- “Да хүрээ” худалдааны төвд ажил үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж иргэд та галын аюулаас урьдчилан сэргийлж дараах санамжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг та бүхэнд анхааруулж байна
- Үйл ажилгаа дууссаны дараа цахилгаан болон хийн тоног төхөөрөмжийг салгаж унтрааж байх ажлын байраа хааж гарахын өмнө дахин нягтлах
- Ажлын байранд шатаж дэлбэрэх зүйл хадгалахгүй байх
- Ердийн галлагаатай бол пийшин, халаагч ус буцалгагч зэрэг цахилгаан хэрэгсэл залгаж орхихыг хатуу хориглоно

Да хүрээ худалдааны төвийн захиргаа

БИЗНЕС ЭРХЛЭГЧ, ҮЙЛЧЛҮҮДЭГЧДИЙН АНХААРАЛД

Цэвэр цэмцгэр орчинд ажиллаж, амьдрах нь бидний сэтгэл санааг өөдрөг, урам зоригтой байхад нөлөөлж. бичил биетнээр үүсгэгддэг халдварт өвчний өвчлөл багсаж өвчин тархахаас сэргийлдэг.

Хүрээлэн байгаа орчны бохирдолт нь таны эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх тул хогоо хогийн саванд хийж цэвэр орчныг бүрдүүлж хэвшье.

Да хүрээ худалдааны төвийн захиргаа

БИЗНЕС ЭРХЛЭГЧ, ҮЙЛЧЛҮҮДЭГЧДИЙН АНХААРАЛД

Ил задгай хог хаяхаас татгалзаж эрүүл орчин ногоон хөгжлийн төлөө хогоо зориулалтын саванд хийж бусдын хөдөлмөрийг хүндэлье

Да хүрээ худалдааны төвийн захиргаа

БИЗНЕС ЭРХЛЭГЧ, ҮЙЛЧЛҮҮДЭГЧДИЙН АНХААРАЛД

Хоггүй орчин бий болгоход иргэн бүрийн оролцоо чухал Тиймээс хоггүй цэвэр, эрүүл орчинд хамтдаа уриалж байна.

Да хүрээ худалдааны төвийн захиргаа

Үйлчлүүлэгч бизнес эрхлэгчдийн анхааралд

Дэлхий дээрх цэвэр усны нөөц маш хязгаарлагдмал төдийгүй олон хүчин зүйлээс шалтгаалан багасч байгаа билээ. Хүрэлцээ муутай бохирдсон хадгалалтын хувьд чанарын болон эрүүл ахуйн шаардлага хангаагүй ус хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй тул усны эх булгаа цэвэр байлгахын тулд хогоо ил задгай хаяхгүй, зориулалтын саванд хаяхыг уриалж байна.

Да хүрээ худалдааны төвийн захиргаа

Үйлчлүүлэгч бизнес эрхлэгчдийн анхааралд

Гэрийн нөхцөлд усны чанар аюулгүй байдлыг хангах зорилгоор усны сав, ус шанагыг угааж ариутгахдаа дараах зүйлсийг анхаарна уу. Үүнд:

- Усны савыг 7 хоногт 1 - 2 удаа буюу шинээр ус авах тохиолдол бүрд хүнсний зориулалтын сав суулга, аяга таваг угаагч бодистой бага зэргийн усаар, богино зөөлөн үстэй сойзоор сайтар сойздон угааж, цэвэрлэнэ.
- Усны савыг угаасны дараа цэвэр усаар сайтар зайлж угаасан бодисыг бүрэн цэвэрлээд ундны усаа хийнэ.
- Усыг хутгах шанагыг усны савны нэгэн адил угааж цэвэрлэх бөгөөд зөвхөн усыг хутгах зориулалтаар хэрэглэж усны чанар аюулгүй байдлыг хангана.
- Ус зөөх сав нь тагтай, цэвэрлэж ариутгах боломжтой байх нь зүйтэй.

Та дээрхи зөвлөмжийг амьдралдаа хэрэгжүүлж ундны усыг гэрийн нөхцөлд зөөх, хадгалах явцад бохирдохоос сэргийлэх нь гэдэсний халдварт өвчин, суулгалт халдварын өвчлөл үүсэхээс өөрийгөө болон гэр бүлээ хамгаалахад ихээхэн ач холбогдолтой юм.

Да хүрээ худалдааны төв

Үйлчлүүлэгчдийн анхааралд

Хэрэглээний ус зөөвөрлөх саваа сайтар угааж, цэвэрлэж үйлчлүүлнэ үү. Бохир саванд хэрэглээний ус түгээхгүй болохыг анхаарна уу.

Да хүрээ худалдааны төв

Хэрэглэгч үйлчлүүлэгч түрээслэгчдэд

Бидний эрүүл мэнд болон байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа зүйл бол хөрсний бохирдол юм хөрсийг хамгийн ихээр бохирдуулдаг зүйлс бол ахуйн гаралтай хатуу шингэн хог хаягдал хүн амьтны ялгадас агаар усны бохирдол байдаг.

Хөрсний бохирдлоос сэргийлэхийн тулд ус агаарын бохирдлыг багасгах ил задгай бие засаж нус цэрээ хаяхгүй эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн бие засах газраар үйлчлүүлж ажиллаж амьдарч буй орчин тойрондоо хогоо ил задгай хаяхгүй хогийн зориулалтын цэгт хаяж хэвших явдал юм.

Да хүрээ худалдааны төвийн захиргаа

САНАМЖ

Хүйтэн сэрүүн болж байгаатай холбогдуулан өрөө, тасалгаандаа халаагуур, тенеэ залгаатай орхихоос сэргийлэж гарахдаа салгаж унтрааж байхыг анхааруулья.

“Да хүрээ трейд” ХХК-ийн захиргаа

Хогийн цэг, хогийн савны зураг



